

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРИН ЗУРГААДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны есдүгээр сарын 03-ны 14 цаг 06 минутад эхэлж, 16 цаг 06 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Санхүүгийн зохицуулах хорооны зарим удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Үнэт цаасны зохицуулалтын газрын Үнэт цаасны бодлогын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар</li><li>- Үнэт цаасны зохицуулалтын газрын Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар</li><li>- Хяналт шалгалтын газрын Бичил санхүүгийн хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар</li><li>- Бүртгэл зөвшөөрлийн газрын Бүртгэл, мэдээллийн албаны даргын албан тушаалд томилуулахаар</li><li>- Бүртгэл зөвшөөрлийн газрын Хяналт үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах Комиссын саналыг танилцуулах</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Батсайханы Энхбатыг Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын Үнэт цаасны бодлогын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Шуураагийн Түмэнбаярыг</p>

		<p>Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Батбилэгийн Төгөлдөрийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын Бичил санхүүгийн хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Оргодолын Мөнгөнцэцэгийг Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Бүртгэл, мэдээллийн албаны даргын албан</p>
--	--	---

		<p>тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч, уг хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Төгс-Эрдэнэ тус хорооны Ажлын албаны даргын 2008 оны 07 дугаар сарын 10-ны 63 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу өөрийн хүсэлтээр төрийн захиргааны албан тушаалаас чөлөөлөгдсөн бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй тул энэхүү ажлын байрыг нийтэд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах нь зүйтэй гэж үзлээ.</p>
2	<p>Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүн тайлан хэлэлцэх, зарим албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар</li> <li>- Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын, Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын талаар танилцуулах</li> </ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баавгайн Насанбаярыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</li> <li>2. Нөөцөд бүртгэгдсэн Баавгайн Насанбаярыг Боловсрол, соёл,</li> </ol>

		<p>шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Булга-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад хүн бүртгүүлээгүй учир Орхон аймгийн ИТХ-аас ирүүлсэн 2015 оны 369 тоот албан бичгээр дахин зарлахаар шийдвэрлэлээ.</p> <p>Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар 2015 оны наймдугаар сарын .. ны өдөр зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүнг Төрийн нарийн бичгийн дарга Ганцогтод албан тоотоор танилцуулахаар шийдвэрлэлээ.</p>
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай	<p>Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржийн 2015 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 01/1058 тоот албан бичгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2015 оны 9 дүгээр сарын 28-29-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
4	Санхүүгийн зохицуулах хорооны зарим албан тушаалд томилогдох удирдах	<p>Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгийн</p>

	<p>ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үнэт цаасны зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох</li> <li>- Хяналт шалгалтын газрын даргын албан тушаалд томилогдох</li> <li>- Зах зээлийн хөгжлийн газрын даргын албан тушаалд томилогдох</li> <li>- Даатгалын зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох</li> </ul>	<p>2015 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 3/3662 тоот албан бичиг, захиалгаар: Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын даргын, Даатгалын зохицуулалтын газрын даргын, Хяналт шалгалтын газрын даргын, Зах зээлийн хөгжлийн газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2015 оны 9 дүгээр сарын 28-29-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
5	<p>Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт дахин зарлах тухай</p>	<p>2015 оны наймдугаар сарын 25-нд зохион байгуулсан сонгон шалгаруулалтаар Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй тул уг албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэйгээр дахин зарлаж, 2015 оны 9 дүгээр сарын 28-29-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
6	<p>Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай</p>	<p>Хууль зүйн сайд Д.Дорлигжавын 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 1/3229 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 9 дүгээр сарын</p>

		28-29-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
7	Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "нэг"-ийн 8-д Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталж, тогтоолд өөрчлөлт оруулах Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн нарийн бичгийн дарга,</li> <li>2. Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газрын дарга,</li> <li>3. Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын дарга,</li> <li>4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,</li> <li>5. Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,</li> <li>6. Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,</li> <li>7. Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн</li> </ol> <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

8	<p>Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/2548 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус Газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн тасгийн ахлах мэргэжилтэн Эрдэнээгийн Наранхүүг 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “хоёр”-ын 6-д “Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ахмад Халзанхүүгийн Жаргал” гэснийг “Хүний нөөцийн тасгийн ахлах мэргэжилтэн Хошууч Эрдэнээгийн Наранхүү” гэж өөрчлөх.</p> <p>3. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Наранхүүд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	<p>Гаалийн ерөнхий газрын улсын байцаагч Х.Мэндсайхан нарын долоон албан хаагчаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлд иргэн Х.Мэндсайхан, Ч.Намуун, Б.Саранзаяа, А.Мөнхзул, Ц.Батхуяг, Т.Тамир, Ч.Цэрэнчунт нараас гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд,</p>

		<p>Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “3.2-т заасныг удирдлага болгон:</p> <p>1.”Гаалийн улсын байцаагчийн эрх олгож, ажилд томилох тухай” Гаалийн ерөнхий газрын дарга Б.Цэнгэлийн 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Б/262 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтаас Баасанцогтын Батхүү, Өлзийсайханы Баярсайхан, Эрдэнэчимэгийн Цолмон, Цэвээннамжилын Жаргал, Тунгалагтамирын Гүндалай, Батмөнхийн Хишигжаргал, Энхтөрийн Мөнхсүвд, Жаргалбатын Алтанбат, Бат-Эрдэнийн Баясгалан, Баасанжавын Болор нарт холбогдох хэсгийг 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн хүчингүй болгох</p> <p>2.Гаалийн байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалд иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Гаалийн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-уудыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг Гаалийн ерөнхий газарт үүрэг болгох.</p> <p>3. Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Гаалийн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтад орж нөөцөд бүртгэгдсэн</p>
--	--	---



		<p>иргэдийг Гаалийн улсын байцаагчаар томилохдоо Гаалийн ерөнхий газрын даргын 2011 оны 270 дугаар тушаалаар баталсан “Судалгаа, хөгжлийн төвийн сургалтын журам”-ын 2.3-т заасан Чиглүүлэх сургалтын хугацааг (45 хоногоос доошгүй) баримталж ажиллахыг Гаалийн ерөнхий газарт даалгах.</p> <p>4.Төрийн албаны зөвлөлийн энэхүү тогтоолын биелэлтийг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу хангаж ажиллахыг Гаалийн ерөнхий газарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
10	Зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, хоёр албан хаагчид тэргүүн түшмэлийн, нэг албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв</p>